



Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 7.7 дахь заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.16 дахь заалт, Гаалийн Ерөнхий Газрын Мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн гэрчилгээ болон таних тэмдгийг батлагдсан загварын дагуу хэвлүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дэд дарга /Ц. Гэндэнцэвээн/-д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Журам батлах тухай” А/288 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



1439501 1136

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАНДАРТЫГ ХАНГАСАН АЖ АХУЙН НЭГЖИД ГААЛИЙН ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Олон улсын бараа нийлүүлэлтийн сүлжээний аюулгүй байдлыг хангах, хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, гааль, бизнесийн түншлэлийг хөгжүүлэх зорилгоор гаалийн харилцаанд оролцогч аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгоно.

1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үүсгэн байгуулагдсан, олон улсын бараа нийлүүлэлтийн сүлжээнд тодорхой үүрэг гүйцэтгэн оролцдог, энэ шалгуурын дагуу гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл олгосон аж ахуйн нэгжийг “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж” гэнэ.

1.3. Гаалийн байгууллагаас тогтоосон шалгуурыг хангаж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гаалийн удирдах төв байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу үнэлж дүгнэн, баталгаажуулж, хүлээн зөвшөөрсний үндсэн дээр гаалийн итгэмжлэл олгоно.

1.4. Гаалийн байгууллага гаалийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид энэ журмын 2.1.1-2.1.4-т заасан шалгуурыг хангасан тохиолдолд гадаад худалдааны үйл ажиллагааны дараах төрлөөр гаалийн итгэмжлэл олгоно:

1.4.1. экспортын үйл ажиллагаа;

1.4.2. импортын үйл ажиллагаа.

1.5. Гаалийн байгууллага нь гаалийн итгэмжлэлийг нэг аж ахуйн нэгжид энэ журмын 1.4.1-1.4.2-т заасан төрлийг дангаар болон хослуулан олгож болно.

1.6. Гаалийн итгэмжлэл олгох, татгалзах, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

1.7. Гаалийн итгэмжлэлийг гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар гурван жил хүртэл хугацаагаар олгоно.

1.8. Гаалийн итгэмжлэл авахыг хүссэн аж ахуйн нэгж, түүний бараа нийлүүлэлтийн сүлжээ болон бусад холбогдох үйл ажиллагаа нь гаалийн итгэмжлэлд тавигдах шалгуурыг хангаж буйг гаалийн байгууллагаас бичиг баримтын болон ажлын байранд шалгаж, нотлон, баталгаажуулалт хийнэ.

1.9. Баталгаажуулалт нь аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авах, мэдээлэлд эрсдэлийн дүн шинжилгээ хийх, ажлын байранд тавигдах шалгуурыг хангаж буй эсэхийг үнэлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, үр дүнг тайлагнах зэрэг үе шаттай үйл ажиллагаагаас бүрдэнэ.

1.10. Итгэмжлэл авахыг хүссэн аж ахуйн нэгжид баталгаажуулалтыг эрх бүхий гаалийн улсын байцаагч хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Гаалийн итгэмжлэл олгоход тавигдах шалгуур

2.1. Монгол Улсад бүртгэлтэй энэ журмын 1.4-т заасан төрлөөр сүүлийн гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан, дараах үндсэн дөрвөн төрлийн шалгуурыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгоно:

- 2.1.1. хууль сахилтын түвшин сайн гэж тогтоогдсон байх;
- 2.1.2. аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны дотоод хяналт сайн байх;
- 2.1.3. санхүүгийн чадавхитай байх;
- 2.1.4. гадаад худалдааны аюулгүй байдлын стандартыг чанд сахих.

2.2. Энэ журмын 2.1.1-2.1.4-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг энэ журмын Нэгдүгээр хавсралтад заасан аж ахуйн нэгжид тавигдах шалгуур үзүүлэлт, өөрийн үнэлгээний дагуу үнэлнэ.

Гурав. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид үзүүлэх хөнгөлөлт

3.1. Гаалийн байгууллагаас гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид дараах хөнгөлөлтийг үзүүлж болно:

- 3.1.1. гаалийн бүрдүүлэлтийг дараалал харгалзахгүй хийх;
- 3.1.2. барааг эзэмшигчийн байр, агуулах, талбайд түр хадгалах;
- 3.1.3. нийт гаалийн бүрдүүлэлтийн 90 хүртэлх хувийг бараанд хийх шалгалтаас чөлөөлөх;
- 3.1.4. нэг сарын хугацаанд нэг гаалийн байгууллагын хяналтад орсон, нэг илгээгчээс хэд хэдэн ачилтаар нийлүүлэгдэх нэг төрлийн бараанд багцалж гаалийн нэг мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлтийг дор дурдсанаас бусад тохиолдолд хийх боломжийг олгох;
 - 3.1.4.1. гэрээний нэгж үнэ өөрчлөгдсөн;
 - 3.1.4.2. гаалийн болон бусад татварын хувь хэмжээнд өөрчлөлт орсон;
- 3.1.5. гаалийн хууль тогтоомжийн болон гаалийн үйл ажиллагаатай холбоотой аливаа санал, гомдлыг нэн даруй шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх үүрэг бүхий гаалийн улсын байцаагчийг гаалийн удирдах төв байгууллагаас тусгайлан томилох;
- 3.1.6. итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн талаар олон нийтэд сурталчлах;
- 3.1.7. гаалийн бүрдүүлэлтийг барааны байршлаас үл хамааран аль ч гаалийн байгууллагад хийх;
- 3.1.8. итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулсан бусад улс оронд хөнгөлөлт эдлэх.

3.2. Гаалийн байгууллагаас энэ журмын 3.1.1.-3.1.8.-д заасан хөнгөлөлтийг тухайн гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид тусгайлан зааж, хамтран ажиллах гэрээнд тусгана.

3.3. Хөнгөлөлтийг зөвхөн гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж эдлэх ба тухайн аж ахуйн нэгжийн харилцан хамааралтай аж ахуйн нэгжид хамаарахгүй.

Дөрөв. Гаалийн итгэмжлэл авах хүсэлт гаргах

4.1. Гаалийн итгэмжлэл авахыг хүссэн аж ахуйн нэгж дараах бичиг баримтыг бүрдүүлж, хүсэлтийг хамт гаалийн удирдах төв байгууллагад гаргана. Үүнд:

- 4.1.1. гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тусгасан аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 4.1.2. энэ журмын Нэгдүгээр хавсралтад заасан аж ахуйн нэгжид тавигдах шалгуур үзүүлэлт, өөрийн үнэлгээний хуудас, түүнд заасан шалгуурыг хангаж байгааг нотолсон бичиг баримт;

4.1.3. татварын өр, авлагагүй болохыг нотлох татварын байгууллагын тодорхойлолт;

4.1.4. хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй болохыг тодорхойлсон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт;

4.1.5. аж ахуйн нэгжийн удирдлага ял шийтгэл эдэлж байгаагүй тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

Тав. Гаалийн итгэмжлэл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид баталгаажуулалт хийх, итгэмжлэл олгох

5.1. Гаалийн итгэмжлэл авахыг хүссэн аж ахуйн нэгжийн хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагын асуудал хариуцсан нэгж хянаж, шаардлага хангасан тохиолдолд баталгаажуулалтыг гаалийн удирдах төв байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу хийнэ.

5.2. Шаардлагатай тохиолдолд удирдамжийн хугацааг гаалийн удирдах төв байгууллагын дарга, эсхүл гаалийн удирдах төв байгууллагын даргын эрх олгосноор асуудал хариуцсан нэгжийн дарга нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

5.3. Баталгаажуулалтын явцыг фото зураг, дүрс болон дуу-дүрсний бичлэг, тэмдэглэл зэргээр баримтжуулна.

5.4. Гаалийн байгууллагад аж ахуйн нэгжийн гаргасан хүсэлтийг дараах шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.

5.4.1. өөрийн үнэлгээний хуудас дахь мэдээлэл хоорондоо тохирохгүй;

5.4.2. өөрийн үнэлгээний хуудас, түүнд агуулагдах мэдээллийг нотолсон бичиг баримт хангалтгүй;

5.4.3. энэ журмын 7.5-д хамаарах аж ахуйн нэгж итгэмжлэлийн хүсэлтийг хугацаанаас өмнө гаргасан;

5.4.4. энэ журмын 5.5-д заасан хугацаанд бичиг баримтыг гаргаж өгөөгүй.

5.5. Бичиг баримтын болон ажлын байрны баталгаажуулалтыг хийх явцад шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээллийг гаалийн байгууллага хүсэлт гаргасан аж ахуйн нэгжээс гаргуулж болно.

5.6. Баталгаажуулалт хийх эрх бүхий албан тушаалтан хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид итгэмжлэл олгох, хүчингүй болгох асуудлыг гаалийн удирдах төв байгууллагын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэнэ.

5.7. Баталгаажуулалтын үнэлгээ нийт шалгуурын онооны 90 хувь буюу түүнээс дээш бол хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл авах шалгуурыг хангасан гэж үзнэ.

5.8. Гаалийн итгэмжлэлийг энэ журмын Хоёрдугаар хавсралтад заасан хатуу дугаар бүхий гэрчилгээгээр баталгаажуулна.

5.9. Гаалийн итгэмжлэлийг Гаалийн удирдах төв байгууллагын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Гаалийн ерөнхий газрын дарга олгож, хамтран ажиллах гэрээг байгуулна.

5.10. Баталгаажуулалтын үнэлгээ энэ журмын 5.7-д заасан үнэлгээний хувьд хүрээгүй бол тухайн аж ахуйн нэгжид “Гаалийн итгэмжлэл” олгохоос татгалзаж, зөвлөмж хүргүүлнэ. Зөвлөмжид татгалзсан үндэслэл, гаалийн итгэмжлэл авахад анхаарах асуудлыг тодорхой тусгана.

5.11. Гаалийн байгууллага төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтантай хамтран баталгаажуулалт хийж болно.

Зургаа. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах

6.1. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид зөвлөмж, мэдээлэл өгөх, энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих үүрэг бүхий гаалийн улсын байцаагчийг томилж ажиллуулна.

6.2. Энэ журмын 6.1-д заасан асуудал хариуцсан гаалийн улсын байцаагч итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн мэдээлэл, хүсэлт, гомдлыг холбогдох удирдах албан тушаалтанд танилцуулж, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

6.3. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж нь энэ журмын Гуравдугаар хавсралтад заасан “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж”-ийн товчлол “АЕО” таних тэмдгийг ашиглана.

Долоо. Гаалийн итгэмжлэлийн хугацааг сунгах, хүчингүй болгох

7.1. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж нь итгэмжлэл хүчинтэй байх хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө албан бичгээр гаалийн удирдах төв байгууллагын асуудал хариуцсан нэгжид итгэмжлэлийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргана.

7.2. Гаалийн удирдах төв байгууллага дараах шалгуурыг хангаж байгаа тохиолдолд итгэмжлэлийн хугацааг энэ журмын 1.7-д заасан хугацаагаар сунгана.

7.2.1. гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж нь итгэмжлэл хүчинтэй байх хугацаанд холбогдох хууль тогтоомж зөрчөөгүй;

7.2.2. баталгаажуулалтаар гаалийн байгууллагаас тогтоосон шалгуурыг дахин хангасан;

7.3. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн итгэмжлэлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно.

7.3.1. гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж өөрөө хүсэлт гаргасан;

7.3.2. гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн итгэмжлэлийн хугацаа дууссан;

7.3.3. энэ журмын 7.1-д заасан хугацаанд итгэмжлэлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргаагүй.

7.3.4. энэ журмын Нэгдүгээр хавсралтын гуравт заасан “Аж ахуйн нэгжид тавигдах шалгуур үзүүлэлт, өөрийн үнэлгээ”-ний шалгуур үзүүлэлтийн 15-д “Байгууллагын хууль сахисан байдал” хэсэгт дурдсан гаалийн болон холбогдох хууль тогтоомжийн зөрчил үйлдэж, хариуцлага тооцогдсон;

7.3.5. гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж татан буугдсан, дампуурсан, өөр аж ахуйн нэгжтэй нэгдсэн, албан ёсны нэрээ өөрчилсөн;

7.3.6. гаалийн байгууллагаас тогтоосон шалгуурын онооны 90 хувьд хүрэхгүй болсон;

7.3.7. гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;

7.3.8. аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулагч, компанийн 10 хувь ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч, аж ахуйн нэгжийн удирдлага сүүлийн хоёр жилд гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлсэн;

7.4. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж нь гаалийн итгэмжлэлийг хүчингүй болгох хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар хүчингүй болгоно.

7.5. Гаалийн итгэмжлэл нь хүчингүй болсон аж ахуйн нэгж нэг жилийн дараа итгэмжлэл дахин шинээр авах хүсэлт гаргаж болно.

Гаалийн ерөнхий газрын даргын
2021 оны 11 дугаар тушаалаар батлагдсан
журмын Нэгдүгээр хавсралт

**ГААЛИЙН ИТГЭМЖЛЭЛ АВАХЫГ ХҮССЭН АЖ АХУЙН НЭГЖИЙН
ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Нэг. Ерөнхий мэдээлэл, баталгаа:

А. Аж ахуйн нэгжийн талаарх мэдээлэл	
1. Аж ахуйн нэгжийн нэр:	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар:
3. Аж ахуйн нэгжийн хаяг:	
4. Утас:	5. Факс:
6. Байгуулагдсан огноо:	7. Цахим хуудас:
8. Үйл ажиллагааны чиглэл:	9. Салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын нэр, хууль ёсны хаяг: 1. 2. ...
Б. Аж ахуйн нэгжтэй холбоо барих	
Аж ахуйн нэгжийн удирдлага/захирал	
10. Овог, нэр:	11. Албан тушаал
12. Утас:	13. Факс:
14. И-мэйл:	
Холбоо баригч	
15. Овог Нэр:	16. Албан тушаал:
17. Утас:	18. Факс:
19. И-мэйл:	
В. Бүрдүүлэх бичиг, баримт	
20. Гаалийн ерөнхий газарт дараах материалыг бүрдүүлж өгнө: 1. аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 2. татварын байгууллагаас татварын өргүй тодорхойлолт; 3. цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 4. гаалийн итгэмжлэл авахыг хүссэн аж ахуйн нэгжийн өөрийн үнэлгээний хуудас.	

Г. Бизнесийн гол түншлэгчдийн мэдээлэл		
Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хамтран ажилласан хугацаа
Д. Баталгаа		
21. Би /бид/ дээрх мэдээллийн үнэн зөв болохыг баталж байна.		
22. Энэхүү өргөдөлд тусгасан аливаа мэдээлэл өөрчлөгдсөн даруйд Гаалийн ерөнхий газарт өөрчлөгдсөн мэдээллийг хүргүүлнэ.		
23. Гаалийн итгэмжлэл хүсэх өргөдөл гаргаснаар би /бид/ түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг уншиж танилцсаны үндсэн дээр дагаж мөрдөхөө баталгаажуулж байна.		
24. Баталгаажуулсан этгээдийн овог нэр:		
25. Албан тушаал:	26. Утас:	
27. Факс:	28. И-мэйл:	
29. Огноо:	30. Гарын үсэг	

Хоёр. Бусад мэдээлэл:

Гаалийн итгэмжлэл авах хүсэлт гаргахаас өмнө “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийн гарын авлага”-ыг уншиж танилцахыг зөвлөж байна.	
Танай байгууллага гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж болохын тулд хийх бэлтгэл ажлыг ямар асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан хариуцах вэ?	
1.	Аж ахуйн нэгжийн мэдээлэл
1.1.	Аж ахуйн нэгжийн талаарх ерөнхий мэдээлэл
1.1.1.	Хүсэлт гаргаж байгаа аж ахуйн нэгжийн нэр, хаяг, байгуулагдсан огноо, аж ахуйн нэгжийн гэрчилгээ, интернэт цахим хуудас. Танай аж ахуйн нэгжтэй хамааралтай дараах нөхцөл хангасан аж ахуйн нэгжийг нэрлэнэ үү. а) Гаалийн итгэмжлэл авсан б) Гаалийн итгэмжлэл авах хүсэлт гаргасан, эсхүл одоогийн байдлаар гаалийн байгууллагын шалгалтад орж байгаа
1.1.2.	Дараах мэдээллийг дэлгэрэнгүй өгнө үү. а) Эзэмшиж байгаа хувьцаа, гол хувьцаа эзэмшигчийн мэдээлэл б) Хилийн чанадад байгаа гишүүд, удирдлагын талаарх мэдээлэл с) Удирдлагын зөвлөлийн багийн талаарх мэдээлэл <i>*Мэдээлэл гэдэгт бүтэн овог нэр, хаяг, төрсөн он сар өдөр, регистрийн дугаар орно.</i>
1.1.3.	Танай аж ахуйн нэгжийн гаалийн асуудал хариуцсан албан тушаалтны мэдээлэл:
1.1.4.	Худалдааны талаарх үйл ажиллагааг танилцуулна уу. Бараа нийлүүлэлтийн сүлжээнд ямар үүрэгтэй оролцдог болохыг тодорхойлно уу.
1.1.5.	Гуравдагч оронд дараах төрлийн үйл ажиллагаа явуулдаг салбарын оршин байгаа

	байршлын хаяг, холбоо барих хүний овог нэр хаяг, утас, имэйл. Хэрэв шаардлагатай бол үйл ажиллагааны танилцуулга: а) Танай аж ахуйн нэгжийн статустай компанийн байршил (нэгж бүрд ажиллаж байгаа ажилчдын тоо) б) Танай аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс өөр эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулдаг гуравдагч этгээдийн байршил
1.1.6.	Танай компани худалдах, худалдан авах үйл ажиллагаа явуулдаг уу? Тийм/Үгүй
1.1.7.	Танай компанийн дотоод зохион байгуулалтын бүтэц болон нэгж тус бүрийн чиг үүрэг
1.1.8.	Удирдлагын багийн танилцуулга, чиг үүргийн талаар товч мэдээлэл
1.1.9.	Нийт ажилчдын тоо
1.1.10.	а) Танай аж ахуйн нэгжид гаалийн чиглэлээр мэргэшсэн эксперт эсхүл ажилчны овог нэр, албан тушаал б) Танай аж ахуйн нэгжийн гааль, гадаад худалдааны чиглэлийн мэдээллийн технологийг ашигладаг албан тушаалтны мэдлэгийн түвшний товч мэдээлэл
1.2	Нийт хөрөнгийн дүн
1.2.1.	а) Сүүлийн гурван жилийн байдлаар жилийн нийт эргэлтийн хөрөнгийн дүн: б) Сүүлийн гурван жилийн байдлаар жилийн нийт цэвэр ашиг, цэвэр алдагдал:
1.2.2.	Хэрэв танай компани агуулах, байр талбай түрээсэлдэг бол, түрээслэгчийн талаар мэдээлэл өгнө үү.
1.2.3.	Сүүлийн гурван жил /жил тус бүр/ гаалийн байгууллагад мэдүүлсэн мэдүүлгийн тоо, түүнд мэдүүлсэн барааны үнийн дүн: • Импорт: • Экспорт: • Дамжин өнгөрөх:
1.2.4.	Сүүлийн гурван жил /жил тус бүр/ танай компанийн төлсөн гаалийн болон бусад татварын өр авлага, хураамж, торгуулийн үнийн дүн • Гаалийн татвар: • Онцгой албан татвар: • Албан татвар: • НӨАТ: • Хураамж: • Өр: • Авлага: • Торгууль:
1.2.5.	а) Ирэх 2 жилд танай компани бүтэц зохион байгуулалтын хувьд ямар нэгэн өөрчлөлт хийх урьдчилсан төлөв байгаа эсэх. Тийм/үгүй Хэрэв тийм бол энэхүү өөрчлөлтийн талаар товч танилцуулна уу. б) Ирэх 2 жилд танай компани бараа нийлүүлэлтийн сүлжээнд томоохон өөрчлөлт хийх урьдчилсан төлөв байгаа эсэх. Тийм/үгүй Хэрэв тийм бол энэхүү өөрчлөлтийн талаар товч танилцуулна уу.

Гурав. Аж ахуйн нэгжид тавигдах шалгуур үзүүлэлт,өөрийн үнэлгээ:

Шалгуур			Дүгнэх оноо			
I. Дотоод хяналт			Тийм (0)	Ерөнхийдөө тийм (-1)	Үгүй (-2)	Тайлбар
Шалгуурын төрөл	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тайлбар				
I. Бүтэц зохион байгуулалт	1. Дотоод бүтэц	1.Экспорт, импорт, санхүү, нягтлан бодох, дотоод удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан тусдаа нэгж байгаа эсэх; 2.Гаалийн асуудал хариуцсан ахлахаас дээш албан тушаалтныг томилсон, байгууллагын даргын тушаал байгаа эсэх;				
	2.Гаалийн хэргийн мэдлэгийг бэхжүүлэх сургалт	1.Гаалийн болон бусад хууль тогтоомж, олон улсын худалдааны дүрэм, журмын талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл өгдөг эсэх; 2.Гаалийн асуудал хариуцсан удирдах албан тушаалтан, хуулийн зөвлөх нь жилд 1-ээс доошгүй удаа гаалийн хууль тогтоомж, гадаад худалдааны чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан эсэх;				
II. Гадаад худалдааны үйл ажиллагаа	3. Бичиг баримтын хяналт	1.Гадаад худалдааны үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг хянадаг, гаргасан алдааг засч, залруулдаг эсэх;				
	4.Бичиг баримтын хадгалалт	1.Сүүлийн 5 жилийн бүртгэл, мэдээллийг Архивын ерөнхий газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу				

		хадгалдаг эсэх; 2. Гадаад худалдааны бичиг баримт, гаалийн мэдүүлэг, тусгай зөвшөөрлийг хадгалж архивладаг эсэх;				
III. Дотоод аудит	5. Дотоод аудитын систем	1.Гадаад худалдааны үйл ажиллагаанд дотоод аудит хийх тусгай бие даасан нэгжтэй байх эсхүл гаднаас мэргэжлийн аудитын баг ажиллуулдаг эсэх; 2.Дотоод аудитыг жилд нэгээс доошгүй хийж тайланг хадгалдаг эсэх;				
	6. Хариуцлагын тогтолцоо	1.Гадаад худалдааны үйл ажиллагаанд хууль бус үйлдэл гаргасан хүнд хариуцлага тооцдог тогтолцоо бий эсэх; 2.Өөр этгээдийн барааг хувиараа зуучлан мэдүүлэх, гаалийн байгууллагын ажилтанд авилга өгөх, гаалийн байгууллагын нэр ашиглан ашиг хонжоо олох зэрэг хууль бус үйл ажиллагаа нь тогтоогдсон ажилтан, гаалийн зуучлагч нарт хариуцлага тооцдог эсэх;				
	7. Сайжруулах арга хэмжээ	1.Гадаад худалдааны үйл ажиллагаанд гаргасан алдааг засч сайжруулах тогтолцоо бүрдсэн эсэх; 2.Гаалийн байгууллагаас тавьсан шаардлагын хүрээнд засаж сайжруулах үйл ажиллагааг гаалийн асуудал хариуцсан удирдах албан тушаалтанд шууд хариуцуулсан эсэх;				
IV. Мэдээллийн технологи	8. Мэдээллийн систем	1.Гаалийн бүрдүүлэлт, санхүү нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системтэй эсэх; 2.Мэдээллийн системийн аюулгүй, хэвийн ажиллагааг хангах зорилгоор				

		давхар хяналт хийх тусгай ажилтныг томилж ажиллуулдаг, ажилчдыг холбогдох сургалтад хамруулдаг эсэх;				
	9. Мэдээллийн аюулгүй байдал	1.Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах, хамгаалалтын системтэй эсэх. 2.Мэдээллийн системд нэвтрэх тусгай эрх, нууц үгтэй байх бөгөөд нууц үгийг тодорхой давтамжтай өөрчилдөг эсэх; 3.Өгөгдлийг буцааж сэргээх, дахин нөөцлөн хадгалах сервертэй эсэх;				
II. Санхүүгийн чадавхи			Тийм (0)	Ерөнхийдөө тийм (-1)	Үгүй (-2)	Тайлбар
Шалгуурын төрөл	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тайлбар				
V. Санхүүгийн нөхцөл байдал	10. Санхүүгийн бүртгэл мэдээлэл	1.Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт болон санхүүгийн тайланд экспорт, импортын үйл ажиллагааг үнэн зөв, бүрэн гүйцэт тусгасан эсэх; 2.Бүртгэл тооцоо нь үнэн зөв, тасалбар болгосон, тайлангийн хугацаа нь зөв эсэх; 1.Итгэмжлэл авахыг хүссэн аж ахуйн нэгжийн хувьд: Итгэмжлэл хүссэн өргөдөл гаргах үед тухайн жилийн санхүүгийн тайлан үнэн зөв, бүрэн гүйцэд эсэхэд, хууль журмын хүрээнд аудитын шалгалтаар орсон эсэх; 2.Итгэмжлэлийн хугацаа сунгах аж ахуйн нэгжийн хувьд: Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хувьд жил бүрийн санхүүгийн байдал үнэн зөв, бүрэн гүйцэт, хууль журмын хүрээнд аудитын шалгалтад орсон эсэх;				

	11. Санхүүгийн төлбөрийн чадвар	1.Санхүүгийн түргэн хөрвөх харьцаа эрсдэлгүй, эсхүл хэвийн түвшинд байгаа эсэх; 2.Хөрөнгө, өр төлбөрийн харьцаа эрсдэлгүй, эсхүл хэвийн түвшинд байгаа эсэх;				
	12. Ашигт ажиллагаа	1.Үндсэн үйл ажиллагаанаас орох ашгийн түвшин нь эрсдэлгүй, эсхүл хэвийн хэмжээнд байгаа эсэх;				
	13. Татвар төлөх чадвар	1.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг гадаад худалдаа эрхлэгчийн хувьд: Сүүлийн сарын эцсийн байдлаар цэвэр үндсэн хөрөнгийн дүн нь сүүлийн 3 жилд гаалийн байгууллагад төлсөн хамгийн их татварын хэмжээнээс багагүй байгаа эсэх; 2.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй гадаад худалдаа эрхлэгчийн хувьд: Өмнөх оны үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал эерэг үзүүлэлттэй байгаа эсэх;				
III. Хууль сахилт						
Шалгуурын төрөл	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Тийм (0)	Ерөнхийдөө тийм (-1)	Үгүй (-2)	Тайлбар
VI. Хууль, журам сахисан байдал	14. Ажилчдын хууль сахисан байдал	1.Аж ахуйн нэгжийн хуулийн зөвлөх, гаалийн болон санхүүгийн асуудал хариуцсан удирдах албан тушаалтан, удирдлага итгэмжлэл авах хүсэлт гаргасан өдөр хүртэлх сүүлийн 3 жилийн байдлаар эрүүгийн гэмт хэрэгт холбогдоогүй буюу ял, шийтгэлгүй				

		байгаа эсэх;				
	15. Байгууллагын хууль сахисан байдал	<p>1. Аж ахуйн нэгж итгэмжлэл авах хүсэлт гаргасан өдөр хүртэлх сүүлийн 2 жилийн байдлаар Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 11.21.1-11.21.5, 11.21.6, 11.21.8, 11.21.9, 11.21.10, 11.21.11, 11.21.16 дахь заалтыг зөрчсөн зөрчилд холбогдоогүй байх;</p> <p>2. Зөрчлийн тухай хуулийн хуулийн 11.21 дүгээр зүйлийн 11.21.2, 11.21.3, 11.21.4, 11.21.5, 11.21.7, 11.21.12, 11.21.13, 11.21.14, 11.21.15, 11.21.17, 11.21.18 дахь заалт, 15.2 дугаар зүйлийн 15.2.1.1-15.2.1.3 дахь заалтыг итгэмжлэл авах хүсэлт гаргасан өдөр хүртэлх сүүлийн 2 жилд 3 буюу түүнээс дээш удаа зөрчөөгүй байх;</p>				
VII. Гаалийн бүрдүүлэлтийн үйл явц	16. Бүртгэлийн мэдээлэл	1.Гаалийн байгууллагын мэдээллийн санд байгаа аж ахуйн нэгжийн бүртгэлийн мэдээлэл үнэн зөв байх;				
	17. Гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэл	1.Өмнөх болон тухайн жилийн гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдээлэл байх;				
	18. Гаалийн мэдүүлгийн алдаа	1.Гаалийн мэдүүлгийн алдааны хувь хэмжээ нь сүүлийн нэг жилийн хугацаанд нэг улиралд мэдүүлсэн нийт мэдүүлгийн 5-аас дээшгүй хувь байх;				
		2.Алдаагүй мэдүүлгийн тоо сүүлийн нэг жилийн хугацаанд нэг улиралд мэдүүлсэн мэдүүлгийн 85-аас дээш хувь байх;				
19. Татвар төлөлт	1.Гаалийн болон бусад татвар төлөх хугацаа хэтэрсэн гаалийн мэдүүлэг нэг жилд мэдүүлсэн мэдүүлгийн 5-аас доошгүй хувь байх;					

		2.Аж ахуйн нэгж итгэмжлэл авах хүсэлт гаргах хүртэлх сүүлийн нэг жилийн хугацаанд гаалийн болон бусад татвар төлөх хугацаа хэтрүүлсэн, ямар нэгэн зөрчлийн торгуулийг төлж барагдуулаагүй тохиолдол байхгүй байх;				
VIII. Гаалийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлсэн байдал	20. Удирдлага зохион байгуулалтын шаардлага	1. Гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийхийн тулд гаалийн байгууллагаас үнэн бодит мэдээлэл нуун дарагдуулсан, буруу ташаа мэдээлэл өгсөн, гаалийн байгууллагын аудитын шалгалт хийхэд санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой бичиг баримтаар хангаагүй, хойш тавьсан, шалгалтад шаардлагатай холбогдох материал бичиг баримтыг үрэгдүүлсэн, устгасан, гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажилд шалтгаангүйгээр гаалийн байгууллагатай хамтран ажиллахаас татгалзаж байсан тохиолдлууд аж ахуйн нэгж итгэмжлэл авах хүсэлт гаргах хүртэлх сүүлийн 3 жилийн хугацаанд гаргаагүй байх;				
		2. Гаалийн болон бусад аж ахуйн нэгжийн мэдээллийг ашиглан хууль бусаар ашиг орлого олох оролдлого аж ахуйн нэгж итгэмжлэл авах хүсэлт гаргах хүртэлх сүүлийн 3 жилийн хугацаанд гаргаагүй байх;				
		3. Гаалийн улсын байцаагчид авилга өгөхийг оролдсон тохиолдол аж ахуйн нэгж итгэмжлэл авах хүсэлт гаргах хүртэлх сүүлийн 3 жилийн хугацаанд гаргаагүй байх;				

IX. Төлөх боломжгүй гадаад өр зээлгүй	21. Гадаад өр, зээл	Аж ахуйн нэгжийн хуулийн зөвлөх, гаалийн болон санхүүгийн асуудал хариуцсан удирдах албан тушаалтан нь худалдаа аж үйлдвэр, татвар, банк, гадаад валют, мэргэжлийн хяналт болон хууль сахиулах байгууллагын хар жагсаалтад ороогүй, шүүхээс ямар нэгэн ял шийтгэлгүй байх;				
IV. Аюулгүй байдал			Тийм (0)	Ерөнхийдөө тийм (-1)	Үгүй (-2)	Тайлбар
Шалгуурын төрөл	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тайлбар				
X. Байр агуулахын аюулгүй байдлын хяналт	22. Байр агуулахын аюулгүй байдал	Итгэмжлэл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн хашаа, талбай, байр агуулахад зөвшөөрөлгүй бараа тээврийн хэрэгсэл, хүн нэвтрэхээс сэргийлсэн хяналт шалгалтын механизм бүрдүүлсэн байх; 1. Хаалга: хүн болон тээврийн хэрэгсэл нэвтрэхэд хяналт тавих нөхцлөөр хангагдсан байх; 2. Байшин барилгын бүтэц: Байшин барилга нь хууль бус халдлагаас хамгаалсан нарийн зохион байгуулалттай байна; 3. Гэрэлтүүлэг: Орох, гарах, ачаа барааг савлах, хадгалах хэсэг, хашаа болон зогсоолын хэсгийн гэрэлтүүлэгтэй байна; 4. Дуут дохио, хяналтын камер: Дуут дохио, хяналтын камер нь орох, гарах, ачаа барааг савлах, хадгалах хэсэг, хашаа болон зогсоолын хэсгүүдэд суурилагдсан байх; 5. Агуулахын хэсэг: Барааг савлах, хадгалах газарт зөвшөөрөлгүй хүн				

		<p>нэвтрэхээс сэргийлсэн хамгаалалтын систем, ажилтантай байх;</p> <p>6. Цоож, түгжээний хяналт: Гадна дотно цонх, хаалга, хашааны цоож, түгжээ аюулгүй байдлыг хангасан байх. Удирдлага болон хамгаалалтын албанаас бүх цоож түгжээний бүрэн бүтэн байдалд хяналт тавьдаг байх;</p>				
<p>XI. Байр агуулахад нэвтрэх хяналт</p>	<p>23. Байр агуулахад нэвтрэх аюулгүй байдал</p>	<p>Итгэмжлэл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тулд ажилчид болон гаднын этгээд нэвтрэх аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсан дүрэм, заавар итгэмжлэл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид хэрэгждэг байх.</p> <p>1. Ажилчид: Байр, агуулах, талбайд нэвтрэх хяналтыг тавихын тулд ажилчдын нэвтрэх үнэмлэх ашигладаг байх. Удирдлага болон хамгаалалтын албанаас ажилчид болон гаднын зочид төлөөлөгчид өгөх нэвтрэх үнэмлэхийн олголт, хураалтад тогтмол хяналт тавих. Нэвтрэх үнэмлэхийн олголт, хураалт, болон нэвтрэх тоног төхөөрөмжийн өөрчлөлт хийгдэх тухай бүрд бүртгэж баримтжуулдаг тогтолцоо бүрдүүлсэн байх;</p> <p>2. Гаднын төлөөлөгч: Гаднын зочид төлөөлөгч нар ирсэн даруйдаа бичиг баримт бүрдүүлэх зорилгоор зурагтай үнэмлэх олгодог байх ёстой. Бүх зочид төлөөлөгч нарыг тодорхой зааварлагч, хөтөч дагалдуулах ба түр үнэмлэх олгодог байх;</p>				

		3. Зөвшөөрөлгүй нэр хаяг тодорхойгүй хүн нэвтрэх: Зөвшөөрөлгүй нэр хаяг тодорхойгүй хүн нэвтрэхэд асууж лавладаг, тодорхойлж, тогтоосны дараа нэвтрүүлдэг байх. Сэжиг бүхий хүн зөвшөөрөлгүй нэвтрэх бүрд бүртгэж, тэмдэглэдэг байх.				
XII. Ажилчдын аюулгүй байдлын хяналт	24. Ажилчдын аюулгүй байдал	Итгэмжлэл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж шинээр ажилд орох ажилчдыг судалдаг, одоо ажиллаж байгаа ажилчдыг тодорхой хугацаанд шалгаж хяналт тавьдаг тогтсон дүрэм, журамтай байх. Ажилчдын жагсаалт овог нэр, төрсөн он сар өдөр, регистрийн дугаар, албан тушаал зэрэг мэдээллийг агуулсан байх. 1. Ажилд авахаас өмнөх судалгаа: Өргөдөл дээрх мэдээлэл, өмнөх ажлын түүхийг судалж хянасан байх; 2. Үндсэн шалгалт, судалгаа: Шинээр ажилд орох ажилчин өмнө нь ямар нэгэн гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, ажилд орсны дараа тухайн ажилчны ажлын гүйцэтгэл, албан тушаалын онцлог байдалд дахин хяналт тавьдаг байх; 3. Ажилчдыг ажлаас чөлөөлөх, халах журам: Ажилтан ажлаас халагдсан тохиолдолд түүний хувийн хэрэг, үнэмлэх, мэдээллийн системд нэвтрэх эрх, бусад зүйлсийг хураан авч, аюулгүй байдлыг хамгаалдаг байх; 4. Аюулгүй байдлын сургалт: Бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлын талаар мэдлэг мэдээлэл өгөх сургалтыг ажилчдад тодорхой				

		давтамжтай явуулдаг байх.				
XIII. Бизнесийн түншлэлийн аюулгүй байдлын хяналт	25. Бизнесийн түншлэлийн аюулгүй байдал	1.Бизнесийн түншлэлийн бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлыг үнэлж, шаардаж, шалгадаг горим журамтай байх; 2. Энэ шалгуурын хүрээнд худалдааны аюулгүй байдлын шалгуурыг сайжруулахын тулд гэрээ, хэлэлцээр, бусад бичиг баримтыг шаарддаг байх.				
XIV. Ачаа, барааны аюулгүй байдлын хяналт	26. Ачаа, барааны аюулгүй байдал	1.Бараа нийлүүлэлтийн сүлжээн дэх тээвэрлэлт, шилжүүлэн ачилт, хадгалалтын явцад барааны аюулгүй байдал, ёс зүйг хангасан тогтолцоо бүрдсэн байх; 2.Барааны хөдөлгөөн: бараа нь бичиг баримт дээрх мэдээлэлтэй тохирох, жин, марк тэмдэг, хайрцгийн тоог нягтлан шалгах. Ачигдах буюу ирж байгаа барааг захиалгатай тулган шалгах. Барааг хүргүүлэхдээ гарын үсэг, тамгаар баталгаажуулсан хамгаалалтын механизм бүрдүүлэх; 3. Бараа зөрөх: Барааг дутуу, илүү ачих, шинж тэмдэг эрс өөрчлөгдсөн тохиолдол бүрд тэмдэглэл үйлдэж хариу арга хэмжээ авдаг байх.				
XV. Чингэлгийн аюулгүй байдлын хяналт	27. Чингэлгийн аюулгүй байдал	Чингэлэгт байгаа барааг зөвшөөрөлгүйгээр холих, зөвшөөрөлгүй хүн нэвтрэхээс чингэлгийг хамгаалсан арга хэмжээ авдаг байх; 1.Чингэлгийн шалгалт: Барааг ачихаас өмнө чингэлгийг бүхэлд нь ялангуяа цоож түгжээг найдвартай эсэхийг шалгаж үзсэн тухай тэмдэглэл үйлддэг байх; Долоон хэсгийн шалгалт хийдэг				

		байх: урд хана, зүүн тал, баруун тал, шал, тааз / дээвэр, гадна хаалга 2. Лац ломбо: Чингэлэгт стандартын лац, ломбо /PAS ISO 17712/ хэрэглэж, бүртгэж тэмдэглэдэг байх. 3. Чингэлгийн хадгалалт, хамгаалалт: Чингэлэгт зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлж аюулгүй газар хадгалдаг байх. Чингэлэгт зөвшөөрөлгүй нэвтрэх тохиолдол гарах тохиолдолд бүртгэдэг, тайлагнадаг байх.				
XVI. Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын хяналт	28. Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал	1.Тээврийн хэрэгсэлд гаднын зөвшөөрөлгүй бараа, хүн нэвтрэхээс хамгаалсан арга хэмжээ авдаг байх; 2.Тээврийн хэрэгслийг хадгалах: Тээврийн хэрэгслийг гаднын халдлагаас хамгаалсан аюулгүй байдлыг хангасан зогсоолд тавьдаг байх. Гаднын зөвшөөрөлгүй хүн нэвтрэх, ачаа барааг сольсон тохиолдолд тайлагнаж илтгэдэг, хариу арга хэмжээ авдаг механизм бүрдүүлсэн байх.				
XVII. Ослын үед авах арга хэмжээ	29. Ослын үеийн удирдлага зохион байгуулалт	1.Осол гамшиг, аюулгүй байдлын эрсдэл тулгарсан үед хариу арга хэмжээ авах журам, дүрэм, заавар байх; 2. Осол гамшгийн үед хариу арга хэмжээ авах талаарх сургалтыг ажилчдад явуулдаг байх; 3.Осол гамшгийн үед хариу авсан арга хэмжээний талаар тайлагнадаг байх.				

Гаалийн ерөнхий газрын даргын
2021 оны / / дугаар тушаалаар батлагдсан
/ / / журмын Хоёрдугаар хавсралт

“ГААЛИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖ АХУЙН НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭ ”



ГЭРЧИЛГЭЭ № _____
CERTIFICATE № _____

ГИААН-ИЙН ГЭРЧИЛГЭЭ AEO CERTIFICATE

ГИААН-ИЙН НЭР, ХАЯГ: _____
AEO NAME, ADDRESS:

ГИААН-ИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: _____
AEO REGISTRATION
NUMBER:

ГИААН-ИЙН ГЭРЧИЛГЭЭ
ОЛГОСОН ОГНОО: _____
AEO DATE OF CERTIFICATION:

ИТГЭМЖЛЭЛ ОЛГОСОН
БАЙГУУЛЛАГЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:
CONFIRMATION OF ISSUING AUTHORITY:

ИТГЭМЖЛЭЛ
ОЛГОСОН ОГНОО:
DATE OF ISSUE:

ГАДААД ХУДАЛДААНЫ ТӨРӨЛ/ TYPE OF OPERATOR	ХУГАЦААНЫ СУНГАЛТ/ EXTENSION	БАТАЛГААЖУУЛАЛТ/ CONFIRMATION
1. 2. 3. 4. 5. 6.		
1. 2. 3. 4. 5. 6.		
1. 2. 3. 4. 5. 6.		
1. 2. 3. 4. 5. 6.		
1. 2. 3. 4. 5. 6.		
1. 2. 3. 4. 5. 6.		
1. 2. 3. 4. 5. 6.		
1. 2. 3. 4. 5. 6.		

Гаалийн ерөнхий газрын даргын
2021 оны 11 дугаар тушаалаар батлагдсан
118-р журмын Гуравдугаар хавсралт

Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн таних тэмдэгийн загвар

